“ШИВЭЭ-ОВОО” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ О.ОТГОНБААТАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

Огноо:______________№________

**АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ** /төсөл/

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасаныг үндэслэн “Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, холбогдох бусад тайлан, илчлэл тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

***Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл***

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС) болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

***Санал дүгнэлтийн үндэслэл***

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал юм.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

БАЛХАН
ХУУДАС 2
АУДИТ ХХК

- 2012 болон 2013 онд хөрс хуулалт хийгдэж 2014 онд нүүрс олборлолт хийхээр төлөвлөж буй талбайн "Хөрс хуулалтын зардал"-ыг хөрөнгөөр бүртгэж тайлагнаагүй нь "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.**

***Хязгаарлалттай санал, дүгнэлт:***

Дээрх дурьдсаныг эс тооцвол "Шивээ-Овоо" ТӨХК-ийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС) болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу бэлтгэгдсэн байна.

**САНХҮҮГИЙН АУДИТЫН**
**ГАЗРЫН ДАРГА** **С.ЭНХЗАЯА**

3

## "ШИВЭЭ-ОВОО" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2013 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН АУДИТЛАГДСАН ҮЛДЭГДЛИЙН ТЭНЦЭЛ

/төгрөгөөр/

**ХӨРӨНГӨ**

| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 2012.12.31 | 2013.12.31 |
|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 1,125,821,496 | 3,216,339,673 |
| Авлага | 4,988,808,826 | 5,004,177,882 |
| Татвар, НДШ-ын авлага | | 14,239,994 |
| Бараа материал | 12,415,058,228 | 14,703,069,040 |
| Урьдчилж төлсөн зардал, тооцоо | 343,938,690 | 2,589,969,443 |
| Хөрөнгө оруулалтын тооцоо | 1,276,065,060 | 1,276,065,060 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **20,149,692,300** | **26,803,861,092** |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ | | |
| Үндсэн хөрөнгө | 65,655,083,367 | 65,056,674,914 |
| Биет бус хөрөнгө | 660,051,840 | 630,074,112 |
| Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө | 696,965,400 | 696,965,400 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **67,012,100,608** | **66,383,714,426** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **87,161,792,908** | **93,187,575,518** |

**ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ**

| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 2012.12.31 | 2013.12.31 |
|---|---|---|
| Дансны өглөг | 10,965,020,636 | 16,350,710,620 |
| Цалингийн өглөг | 137,626,882 | 197,941,047 |
| Татварын өр | 84,903,368 | 289,050,556 |
| НДШ-ийн өглөг | 129,710,164 | 244,691,991 |
| Банкины богино хугацаат цээл | 2,000,000,000 | 9,758,464,085 |
| Хүүний өглөг | 41,333,333 | |
| Урьдчилж орсон орлого | | 99,332 |
| Нөөц өр | 940,000 | - |
| Богино хугацаат өр төлбөр | | 7,388,982 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **13,359,534,383** | **26,848,346,613** |
| УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | |
| Урт хугацаат зээл | 57,759,456,978 | 53,711,878,146 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **57,759,456,978** | **53,711,878,146** |
| ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ | | |
| Өмч а/ Төрийн | 1,207,710,000 | 1,207,710,000 |
| б/ Хувийн | 134,190,000 | 134,190,000 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 20,271,950,624 | 20,329,391,486 |
| Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг | | |
| Хуримтлагдсан ашиг | (5,571,049,077) | (9,046,940,727) |
| тайлант үе | (4,234,857,386) | (3,260,833,666) |
| өмнөх үе | (1,336,191,691) | (5,786,107,061) |
| **Эзэмшигчдийн өмчийн дүн** | **16,042,801,547** | **12,624,350,759** |
| **Нийт өр төлбөр ба өмч** | **87,161,792,908** | **93,184,575,518** |

БАЛХАГ
хуудас 15

## "ШИВЭЭ-ОВОО" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2013 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2013.12.31 |
|---|---|
| **Борлуулалтын орлого /цэвэр/** | **31,608,061,073** |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 33,070,208,575 |
| **Нийт ашиг /алдагдал/** | **(1,462,147,502)** |
| Түрээсийн орлого | 672,727 |
| Хүүний орлого | 90,278,559 |
| Бусад орлого | 781,739,813 |
| Ерөнхий удирдлагын зардал | 1,408,315,222 |
| Бусад зардал | 1,258,618,578 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз/ | (4,443,463) |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **(3,260,833,666)** |
| 12.Орлого татварын зардал | |
| **Татварын дараах ашиг (алдагдал)** | **(3,260,833,666)** |
| Цөөнхөд ноогдох хувь | |
| **Ердийн ажиллагааны ашиг (алдагдал)** | **(3,260,833,666)** |
| 9. Онцгой шинжтэй зүйлс- цэвэр | |
| **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | **(3,260,833,666)** |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал) | |

БАЛХАН ХУУДАС 16 АУДИТ ХХК

## "ШИВЭЭ-ОВОО" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
## 2013 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН АУДИТЛАГДСАН
## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмч | Халаасны хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| **2013 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл** | **1,341,900,000** | | | **20,271,950,624** | **(5,571,049,077)** | **16,042,801,547** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | (215,057,984) | (215,057,984) |
| **Залруулсан үлдэгдэл** | | | | | **(5,786,107,061)** | **(5,786,107,061)** |
| Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/ | | | | | (3,260,833,666) | (3,260,833,666) |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | | 57,440,863 | | 57,440,863 |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | |
| Зарласан ноогдол ашиг | | | | | | |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | | |
| **2013 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,341,900,000** | | | **20,329,391,486** | **(9,046,940,727)** | **12,624,350,759** |

БАЛХАН
ХУУДАС 17
АУДИТ ХХК

## "ШИВЭЭ-ОВОО" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2013 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2013.12.31 |
|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | |
| **Мөнгөн орлогын дүн** | **29,281,270,864** |
| Борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого | 28,902,056,744 |
| Туслах үйл ажиллагаанаас орсон орлого | 341,856,370 |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 37,357,750 |
| **Мөнгөн зарлагын дүн** | **35,607,828,326** |
| Ажиллагсдад олгосон мөнгө | 4,506,703,840 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө | 1,104,942,657 |
| Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө | 24,029,361,694 |
| Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | 2,554,969,740 |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө | 167,777,871 |
| Бусад мөнгөн зарлага | 576,939,152 |
| Хүүний төлбөрт төлсөн мөнгө | 44,756,587 |
| Татварын байгууллагад төлсөн мөнгө | 2,467,771,051 |
| Даатгалын төлбөрт төлсөн мөнгө | 154,605,735 |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(6,326,557,462)** |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллгааны мөнгөн гүйлгээ** | |
| **Мөнгөн орлогын дүн** | **74,837,968** |
| Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого | 74,837,968 |
| **Мөнгөн зарлагын дүн** | **(2,012,853,772)** |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө | 2,012,853,771 |
| Хүлээн авсан хүү, ноогдол ашиг | |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллгааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(1,938,015,804)** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | |
| **Мөнгөн орлогын дүн** | **12,587,232,044** |
| Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 12,580,000,000 |
| Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 7,232,044 |
| **Мөнгөн зарлагын дүн** | **(2,232,140,602)** |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | (2,112,147,273) |
| Төрөл бүрийн хандив | (115,433,055) |
| Валютын ханшийн зөрүүгийн гарз | (4,560,274) |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **10,355,091,442** |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **2,090,518,176** |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,125,821,496 |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 3,216,339,673 |

БАЛХАН
ХУУДАС 18
АУДИТ ХХК